

□

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН ТУШААЛ

2019 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр

Дугаар А/635

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журмыг хавсралтаар баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, арга зүйгээр хангаж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газар /Ш.Мягмар/-т даалгасугай.
3. Журмын дагуу ус бохирдуулсны нөхөн төлбөр ногдуулах, хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар /Н.Цагаанхүү/-т, сум, дүүргийн байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчид тус тус үүрэг болгосугай.

САЙД Н.ЦЭРЭНБАТ